



2025 оны 02 дугаар
сарын 10-ны өдөр

ТУЗ-03/2025

Улаанбаатар
хот

Эрэнцэв ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59-р зүйлийн 59.4, 60-р зүйлийн 60.1, 60.2, 62-р зүйлийн 62.1, 76-р зүйлийн 76.1-р заалтууд, Эрэнцэв ХК-ийн дүрмийг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн 16:00 цагт хуралдуулсугай.
- Компанийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.2-ын дагуу дараах мэдээллийг баталсугай.
 - Хурал хуралдах газар:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 75/1-10 тоот Эрхэт трейд ХХК-ийн байранд;
 - Хуралдах өдөр, цаг:** 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн 16:00 цагт;
 - Хурлаар хэлэлцэх асуудлууд:** 2024 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах; 2024 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах; ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг дуусгавар болгох; ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох; Бусад;
 - Бүртгэлийн өдөр:** 2025 оны 03-р сарын 01-ний өдөр;
 - Хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр:** 2025 оны 02-р сарын 12, 2025 оны 02-р сарын 27-ны өдөр;
 - Хурлын дарга:** Ц.Лхагвадорж /ТУЗ-ийн дарга/
 - Тооллогын комиссын дарга, гишүүд** Дарга: Л.Даваа, Гишүүд: Г.Одгэрэл, Л.Ням
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, холбогдох баримт бичгийг 2025.02.11-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.
- Хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах комиссыг Ц.Лхагвадорж /комиссын дарга/, Л.Даваа, М.Бат нарын бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Компанийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.4-т заасны дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэл, компанийн цахим хуудас, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2025.02.12, 2025.02.27-ны өдрүүдэд олон нийт, хувьцаа эзэмшигчидэд хүргэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.
- Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх тухай мэдэгдлийг 1-р хавсралтаар баталсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн танилцах Баримт бичгийн жагсаалтыг 2-р хавсралтаар баталсугай.

8. Хурлын тухай олон нийтэд мэдээлэх зарын загварыг 3-р хавсралтаар баталсугай.
9. Компанийн Аудитын бодлогын баримт бичгийн 1.2, 9.1-р заалтууд, Компанийн засаглалын кодексийн 2024 оны тайлангийн 16-р заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулах хөндлөнгийн аудиторыг сонгож ажиллахыг Аудитын хороо /Н.Баярсайхан/-нд даалгасугай.
10. Хуралтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг ТУЗ-ийн дарга /Ц.Лхагвадорж/-д зөвшөөрсүгэй.
11. Энэхүү шийдвэрийг олон нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**

